



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Г


ШУТИС-ийн Захирлын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.5, ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 4 дүгээр зүйлийн 4.1, ШУТИС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн Захирлын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “Бүрэн хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. ШУТИС-ийн 2020 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “ШУТИС-2030 стратегийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхлэхэд чиглүүлэн, төлөвлөн ажиллахыг ШУТИС-ийн захирал (Б.Очирбат)-д даалгасугай

ДАРГА

Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2019 оны зарлагын төсөвт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019 оны үйл ажиллагааны зарлагын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын лаборатори, тоног төхөөрөмжийн зардлын зүйлийг 589.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нэгдүгээр хавсралтаар, бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулахыг ШУТИС-ийн захирал (Б.Очирбат), Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ) нарт даалгасугай.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот


ШУТИС-ийн 2020 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, 2020 оны төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020 оны үйл ажиллагааны орлогын төсвийг нэгдүгээр хавсралтаар, зарлагын төсвийг хоёрдугаар хавсралтаар, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ШУТИС-ийн захирал (Б.Очирбат), Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ) нарт даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

“Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг ШУТИС-д харьялзулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 224 дүгээр тогтоол, ШУТИС-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.2, Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/9955 тоот албан бичиг, Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 224 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх Технологийн сургуулийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль болгон өөрчлөн зохион байгуулсныг ШУТИС-ийн бүтцэд нэмж оруулан хавсралтаар баталсугай.

2. Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үүсгэн байгуулсан, ШУТИС-ийн харьяа, хамтын засаглалын удирдлага бүхий дээд боловсролын байгууллага байх асуудлыг шийдвэрлүүлэхээр Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газарт уламжилсугай.

3. Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн Удирдах зөвлөлийг шинээр байгуулж, Удирдах зөвлөлийн болон тус сургуулийн дүрмийг шинээр баталж мөрдүүлэх болон сургалтын материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүнийг хөгжүүлэх талаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Ерөнхий захирал (Х.Бадамсүрэн)-тай хамтран, үе шаттай арга хэмжээ авахыг ШУТИС-ийн Захирал (Б.Очирбат)-д даалгасугай.




ДАРГА

Д.БАДАРЧ



ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны
12-р сарын 05-ны өдрийн 14. тоот тогтоогын хавсралт





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

"ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө" дэмжих тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дүгээр заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.2, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г дэмжсүгэй.
2. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.
3. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнг сайшаасугай.

